

Гарчиг

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
II. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ	3
БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	6
III.1 ТӨСЛИЙН БОЛЗОШГУЙ БОЛОН ГОЛ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	6
IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ.....	10
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ХАМРАХ ХҮРЭЭ	10
V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	11
VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
6.1. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	15
6.2. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
6.3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
6.4. БОЛЗОШГУЙ ЭРСДЛЭЭС ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
6.5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
6.6. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	20
6.7. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ.....	24
6.8. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН НЭГДСЭН ДҮН	24

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол оронд барилгын салбар эрчимтэй хөгжиж, түүнийг дагаад барилгын материалын эрэлт хэрэгцээ нэмэгдэж байна. Улаанбаатар хот болон түүний дагуул хот, дүүргүүдэд Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй 40000 айлын орон сууцны хөтөлбөр, мөн зам барилгын салбарт барилгын материалын эрэлт хэрэгцээ өсч буйг харгалзан, тухайн салбарт өөрсдийн хувь нэмрийг оруулах зорилгоор Улаанбаатар, Сонгино-хайрхан дүүргийн нутагт орших “Өвөр харзат” ХХК-ийн эзэмшлийн Хан-уул дүүргийн 13 дугаар хорооны нутагт элс, хайрганы хольцын ордод 12 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байна.

“Харзатын хотгор” элс, хайрганы хольцын ордын нөөцийн талбайн булангийн цэгүүд нь L-48-10 планшейтын талбайн хэмжээнд дараах газар зүйн солбилцолын хүрээнд хамаарна.

Талбайн нь 189,44 га

14302 А тусгай зөвшөөрөлийн талбайн газарзүйн солбилцолууд

1. $106^{\circ}34'21.3''$ $48^{\circ}41'41.78''$
2. $106^{\circ}33'46.31''$ $47^{\circ}48'41.78''$
3. $106^{\circ}33'46.31''$ $47^{\circ}49'31.78''$
4. $106^{\circ}34'51.34''$ $47^{\circ}49'31.78''$
5. $106^{\circ}34'51.31''$ $47^{\circ}48'51.78''$
6. $106^{\circ}34'21.3''$ $47^{\circ}48'51.78''$

Үйлдвэр нь Улаанбаатар хотоос баруун урагш 30 км. Туул голын баруун цутгал болох Харзатын хотгор хөндийд орших ба эдийн засаг, зам харилцаа өндөр хөгжсөн төвийн бүсэд оршдог.

Бүтээгдэхүүнээ хатуу хучилттай замаар тээвэрлэн Улаанбаатар хотын барилга байгууламжуудыг барих компаниудад нийлүүлнэ.

**II. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ
БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.**

Үйлдвэрийн талаар: Элс хайрганы ил уурхайн жилийн хүчин чадлыг эхний жилд 41.83 мян.м³, хоёр дах жилээс жигд 100.0 мян.м³ элс хайрга олборлож нийт 786.13 мян.м³ элс хайрганы ашиглалтын нөөцийг 9 жил олборлох тооцоо гарч байна. Тухайн үйлдвэр нь БНХАУ-ын тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байдаг. Нийт 30 орчим хүнийг ажлын байраар хангадаг.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“ӨВӨР ХАРЗАТ” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9019012147
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Элс, хайрганы хольцын орд
	4. Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг	Хан-уул дүүрэг 13 дугаар хороо
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Д.Дүгэрсүрэн: Утас 99115031 Цахим хаяг: uvurharzat@gmail.com
	6. Үйлдвэрийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлтийн дугаар	Хүлээн авах комисс ажиллаагүй
	7. ТЭЗҮ баталсан огноо	2012 оны 09 дугаар сарын 17-ны өдөр № 524
	8. Урьд оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	55.7 мян.м ³
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ		
1.2	1. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дугаар хүчинтэй хугацаа	-Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл МҮ-14302 - 2008 оны 10 сарын 16 өдөр олгосон - 30 жилийн хугацаатайгаар олгосон
	2. Галын дүгнэлтийн огноо, дугаар	2022.05.09 Дугаар 0002388

3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан	Баталсан: БОАЖЯам 2019 он
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан	Баталсан: БОАЖЯам 2019 он
5. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	2020 оны 04 сарын 28-ний өдөр

“ӨВӨРХАРЗАТ” ХХК нь элс, хайрганы хольцын ордыг ашиглаж хайрга үйлдвэрлэж буй үйлдвэр нь Хан-уул дүүргийн 13-р хорооны нутаг дэвсгэрт Харзатын хотгор нэртэй газар байрладаг.

Төслийн хэрэгжих өнөөгийн байдал нь: Хан-уул дүүргийн 13 дугаар хорооны байрлах элс, хайрганы орд нь Улаанбаатар хотын Хан-уул дүүрэгт харьяалагдана.

Хан-уул дүүрэг нь дэд бүтцийн хувьд харьцангуй сайн. Нийслэлтэй засмал замаар холбогдсон, зүүн бүсийг хангах цахилгаан дамжуулах өндөр хүчдлийн шугам, радио релей ба холбооны шугам, агаарын ба засмал зам дайран өнгөрдөг.

Гадаргын үс усан хангамж: Элс, хайрганы хольцын үйлдвэрийн байрлаж буй 13-р хорооны нутаг дэвсгэрт булаг шанд гол горхи байхгүй. Барилгын материалын үйлдвэр нь хэрэгцээний усаа өөрийн эзэмшлийн гүний худагын усаар хангадаг.

Геологи нь: Улаанбаатарын дүүргийн геологийн тогтоц нь: PZ2, PZ3, MZ, KZ-н насны тунамал, бялхмал, хувирмал чулуулгаас бүрддэг. Гэвч талбайн геологийн тогтоцод орчин үеийн ангиллаар Карбоны галавын Миссисипийн дэд системийн Серпуховын ярусын зузаалаг, дөрөвдөгчийн сэвсгэр хурдас ажиглагддаг.

Хөрс: Монгол орны хөрс газарзүйн мужлалаар хангайн Их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн Хэнтий Дэд бүсийн Хэнтий захын хөрсний тойрогт хамаарагдах бөгөөд энэхүү бүс нутаг нь ойт хээрийн бүст хамаарагдана. Уг хөрсний судалгаанаас үзэхэд тухайн ордын талбайд хар хүрэн хөрс зонхилон тархсан байна.

Хөрсний бүтцийн өөрчлөлт хөрсөнд агуулагдах тэжээлийн бодисын агуулгыг үзэх зорилгоор дээж авч шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээс үзэхэд мэдэгдэхүйц ялзмагийн агууламж багассан.

Ургамлан нөмрөг: төслийн талбай нь Ургамал газар зүйн мужлалын хувьд ЕвроАзийн шилмүүст ой, нуга хээрийн их мужийн чийглэг хэв шинжийн Өвөр байгалийн Туул-Бархын мужд хамаарагдана. Ургамалын бүлгэмийн хувьд шарилжалаг өвст бүлгэмдэлд багтана. Ил аргаар олборлолт явуулахад хөрс эвдрэлд их хэмжээгээр эвдэрдэг ч ухсан ам, нүх хооронд байгалийн унган төрхөөрөө байгаа талбай багагүй хэмжээтэй байна. Мөн тухайн орчинд нилээд чийглэг учир ургамлын төрөл зүйлийн хувьд нилээд баялаг юм. Үйл ажиллагаа явуулж байгаа талбай нь талхлагдаж ургамлан нөмрөггүй болж хог ургамал ихээр тархсан байна.

Нийгэмд нөлөөлөх байдал: Барилгын материал үйлдвэрлэж элс, хайрга олборлох явцад гарах тоос тэнд ашиглаж буй тоног төхөөрөмж машин техникийн дуу чимээ нь ойролцоо нутаглаж буй ард иргэдэд амьтад нөлөө үзүүлэх нөхцөлтэйгээс амьтад даажих нөхцлийг бүрдүүлдэг.

Хаягдалын менежмент: Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад гарах шингэн болон хатуу хог хаягдлыг төсөл хэрэгжүүлэгч нь тодорхой заагдсан дүрэм стандартын дагуу цуглуулан нэг цэгт төвлөрүүлэн хадгалж зайлуулах үүрэгтэй. Хатуу хог хаягдлыг салхины доод талд зорлуулалтын саван болон хогийн сараа хийж төрөлжүүлэн ялгаж ачуулах ашиглаж болох зүйлийг 2 дахь түүхий эдийн цэгт тушаах шаардлагатай. Үүнтэй уялдсан хог хаягдлын менежментийн төлөвлөгөө хийж дүүргийн ТҮГ хийсэн хог хаягдлын гэрээний дагуу ачуулах ахуйн хэрэглээний бохир усыг байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүйгээр зайлуулах усыг хэмнэж эргүүлэн ашиглах бага оврын био реакторт бохир ус цэвэрлэх байгууламжийг ашиглах шаардлагатай.

Эдийн засаг, нийгмийн асуудлын хувьд шаврыг олборлож тоосго үйлдвэрлэх үйлдвэрлэл нь улс орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах, тодорхой тооны хүмүүсийг улирлаар ажлын байраар хангадаг. Эдгээр нь **шууд бөгөөд урт хугацааны** эерэг нөлөөлөлд хамаарна.

III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

III.1 Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл

Тус төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов.

Одоогоор Харзатын хотгор уурхай усны түвшин лүүгээ ороогүй байгаа ба олборлох үйл ажиллагааны улмаас, чанарт нь өөрчлөлт орох, хөрсний бүтэц, бүрэлдэхүүн, геологийн тогтоц, агаарын төлөв байдал өөрчлөгдөх, ургамал нөмрөг багасах, эрдэс баялгийн төрөл, хэмжээ хомсдох, малын бэлчээрийн талбай устгах, агаарын бохирдол, ландшафтын хэлбэр, байгалийн өнгө төрх өөрчлөгдөх, хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх дуу шуугиан, уурхайг олборлолтын улмаас зэрлэг амьтад дайжих зэрэг сөрөг нөлөөллүүд байж болохын зэрэгцээ орон нутгийн дэд бүтэц сайжрах, орон нутгийн орлого нэмэгдсэнээр ядуурлын түвшинг бууруулах зэрэг нийгэм, эдийн засгийн салбарт үзүүлэх эерэг нөлөөллүүд байна.

Хүснэгт 1. Гол сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, үргэлжлэх хугацаа

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
1	Шимт хөрс хуулалт	Газрын хөрс, бэлчээр, агаар	Хүчтэй	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
2	Олборлолт	Геологийн тогтоц, агаар	Хүчтэй	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
3	Тээвэр	Хөрс, агаар	Дунд зэрэг	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
4	Овоолго	Хөрс, агаар, шимт хөрс	Дунд зэрэг	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
5	Ус ашиглалт	Гүний ус	Дунд зэрэг	Төсөл хэрэгжих бүх хугацаанд

Харзатын хотгор элс, хайрганы хольцын ордын олборлолт тухайн бүс нутагт шууд нөлөөлөл үзүүлэхээс гадна энэ процесс нь олборлолт явагдаж байхад болон олборлолтын дараа байгаль нөхөн сэргээлт хийсэний дараа ч сөрөг нөлөөлөл нь үргэлжилнэ. Сөрөг нөлөөллийн эрчим нь олборлолт эхэлсэнээс хойш ихсэнэ. Элс, хайрганы хольцын ордыг олборлох үйл ажиллагааны улмаас уулын чулуулгийн тогтоц, агаарын чанар, гүний усны хэмжээ, чанар өөрчлөгдөх, хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөллүүд байна.

Төслөөс газрын гадарга, хэвлийд нөлөөлөх байдал

Уурхайн үйл ажиллагааны улмаас 2024 онд ил уурхай, барилга байгууламж, зам, хөрсний овоолго зэрэг нэмэлтээр 1.0 га талбайг хамарсан эвдрэл үүсч байгаль орчинд сөрөг нөлөө учруулна.

Ордыг ашигласнаар газрын гадаргууг өөрчлөхөөс гадна хөрсний бүтэц, дүүргийн гидрогеологийн горимыг өөрчилдөг.

Ил уурхайн аргаар ашигт малтмал, эрдэс түүхий эдийг олборлоход агаарт их хэмжээний тоос гарах нөхцөл бүрддэг. Бульдозер, ачигч зэрэг машин механизмуудаар хөрсийг хуулах овоолго хийх, түүхий эдийг бутлах, ачих зэрэг технологийн процессийн явцад салхитай нөхцөлд тоос ихээр гарч агаарыг бохирдуулах нөлөө үзүүлнэ.

Төслөөс хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг дурдвал:

- Ил уурхайн хил хязгаар дотор хайрга олборлоход “2024 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө” -ний тайланд тусгаснаар нийтдээ 1.0 га талбай нэмж эвдрэлд өртөж 35.06 мян.м³ хөрс хуулна.
- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас болон хүний анхаарал болгоомжгүй байдлаас шатахуун, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Уурхайд хөрсний овоолго хийх, нүүрс, хөрс тээвэрлэх зэрэг үндсэн үйл ажиллагаанд хүнд даацын олон машин ажиллахад хөрс их хэмжээгээр элэгдэл, эвдрэлд орж, хөрсний үржил шим алдагдана
- Хайрга, хөрс тээвэрлэх явцад талбайд элдэв хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, дагтаршсан шороон хэсэг суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай, салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- Хөрсний биологийн нөөц хомсдох, үржил шим нь алдагдах, хуурайших

Төслөөс усан орчинд нөлөөлөх нөлөөлөл

- Одоогийн байдлаар “Харзатын хотгор”-ын уурхайн гүн 5.0 м, хамгийн гүн хэсэгтээ +1267.1 м-ийн түвшинд олборлолт явагдаж байна. 2024 онд олборлох хайрга нь усны түвшингээс дээр түвшинд явагдах ба төлөвлөгөөт онд ус шүрүүлэх ажил гүйцэтгэхгүй учир газрын гүний усны нөөц, горимд сөрөг нөлөөлөл үзүүлэхээргүй байна.

- Аадар борооны үед тус талбайн хойд болон зүүн талаас түр зуурын үерийн ус бууж талбай дахь хөрс, элс, хатуу шингэн хог хаягдал, хагшаас зэргийг урсгаж гадаргын усыг бохирдуулж болзошгүй.
- Төслийн үйл ажиллагаанаас ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал хөрсийг бохирдуулснаас гадаргын болон гүний усанд шууд бусаар нөлөөлнө.
- Газар шорооны ажлын үед газрын доорх ус агуулсан үеийг ухаж хөндөх нь газрын доорх усыг бохирдуулах магадлалтай.

Ургамлан нөмрөгт нөлөөлөх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас дараах байдлаар ургамлын нөмрөгт нөлөөлнө. Үүнд:

- Хог хаягдал салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, гүний усыг бохирдуулах нөхцөл болно,
- Газар шорооны ажлын үед ургамлын үе хөрсийг хуулах,
- Төслийн түүхий эд, материалыг зөөх тээвэрлэх,
- Хөрс хуулах, хөрсний овоолго хийх,
- Төслийн явцад бусад зориулалтаар газар ашиглахад ургамлын төрөл зүйл устаж үгүй болох, хувьсаж өөрчлөгдөх сөрөг нөлөөлөлтэй.

Төсөл хэрэгжих орчны амьтны аймагт нөлөөлөх нөлөөлөл

Хайрганы ордыг ашиглах төсөл хэрэгжүүлэх хугацаанд хүн, машин техникийн дуу чимээ, хөдөлгөөн нэмэгдсэнээс үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Дээрх төрлийн сөрөг нөлөөллөөс шалтгаалан орчны бүс дэх амьтад идээшсэн нутгаасаа дүрвэн зайлах, байршил нутгаа өөрчлөх зэрэг хариу үйлдэл гаргах бөгөөд энэ явцдаа олноор тэжээлийн хомсдол ба орчны өөрчлөгдлийн улмаас үхэж үрэгдэх, бусад махчин амьтдын идэш болох зэрэг зүй бус хорогдолд өртөж болзошгүй юм. Иймд төслийн талбайг эзэмших, уурхайн үндсэн ба туслах үйл ажиллагааг эхлэх хугацаа, горимыг дээрх нөхцөл байдалтай уялдуулан нарийн төлөвлөх, орон нутгийн ан амьтан хамгаалах, малчдын нөхөрлөл, санаачлагуудтай, шаардлагатай гэж үзвэл, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч уулын ажлын үед дагаж мөрдөх хамтарсан төлөвлөгөөтэй ажиллах шаардлагатай. Төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь дараах хүчин зүйлсээр тодорхойлогдоно. Үүнд:

- Техникийн осол аваар
- Ухсан нүхэнд мал, амьтан унаж осолдох

Уурхайн үйл ажиллагааг зохион байгуулалттай явуулж, тээвэрлэлтийн замыг олон салаалуулалгүй, тэмдэг тэмдэглэгээгээр удирдан хязгаарлах нь нутгийн газар ба хөрс, ургамал, амьтдыг хамгаалах нэгэн төрлийн арга хэмжээ болно.

Хог хаягдал, ариун цэвэр бохирын асуудлыг сайтар төлөвлөхгүй бол хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор гэгдэх зүйлүүдийн тоо өсөх магадлалтай.

Төслөөс нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл

Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд:

- Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах
- Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулах,
- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавих
- Ажилчдын ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, хүнд нөхцөлд ажиллагсдад нэмэгдэл цалин, урамшуулал олгох
- Ажилчдын цалинг цаг тухай бүрт нь олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ХАМРАХ ХҮРЭЭ

Уг төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой баримт бичиг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, байгалийн нөөц баялагийг зүй зохистой ашиглах боломж бүрдэхээс гадна төслийн хэрэгжих чадварыг дээшлүүлж, эдийн засгийн үр ашиг нэмэгддэг.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээлгэн өгч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна. Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ.

Энэхүү төлөвлөгөөгөөр Улаанбаатар хотын Хан-уул дүүргийн 13 дугаар хорооны нутагт “Харзатын хотгор” уурхайн ордыг ашиглах үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй болон голлох сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон болно. Уг төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийн хураангуй бөгөөд хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулж тусгай хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллавал илүү үр дүнтэй байх болно. Мөн төлөвлөгөөг орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнтэй уялдуулж, жил бүр хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай.

V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Өвөр харзат” ХХК нь 2024 онд Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд нийт **5 999.1** мян.төгрөгийг зарцуулахаар төлөвлөв. Энд тусгагдаагүй зардлууд нь уулын ажлын болон хөдөлмөр хамгаалалын зардалд тусгагдсан болно. Байгаль хамгаалах сургалт болон сурталчилгааг тус орон нутгийн Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн болон НБОГ-тай хамтран зохион байгуулахаар төлөвлөлөө.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2014 онд БОНХЯ-ны сайдын тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болголоо.

Тус компани байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- ✓ Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- ✓ Байгаль орчны хамгаалах хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөгө болгон ажиллах
- ✓ Олборлолт хийх үед нөлөөлөлд өртөх талбайг хамгийн бага байлгах
- ✓ Ажилчдад сургалт зохион байгуулах
- ✓ БОМТ-г батлуулж, төлөвлгөөний дагуу биелэлтийн тайланг бичих
- ✓ Нутгийн иргэд болон ажилчид, сонирхогч талуудад байгаль орчны асуудлаар нээлттэй, ил тод байлган хурал, хэлэлцүүлэг зохион байгуулна.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1. 2024 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаарын чанар	Машинаас гарах тоос шороог багасгах үүднээс замын гадаргыг шаардлагатай хэсгүүдэд засах	Техникийн хөдөлгөөнөөр үүсэх	-	30.0	-	30.0	5 дугаар сард	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
		Уурхайн орчны авто замын тэмдэг тэмдэглэгээг засах, эвдрэл гэмтэл, арчилгааг тогтмол хийх,			50.0		50.0	5 дугаар сард	
		Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавих			30.0		30.0	Сар бүр	
		Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;			50.0		50.0	5 дугаар сард	
2	Гадаргын ба газрын доори усны нөөц	Хайрганы орд олборлолтын ажлын явцад орчны тоосжилтыг бууруулахад цэвэр усны нөөцийг аль болох ашиглахаас зайлсхийж, цэвэршүүлсэн ахуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах, боломжтой бол ашиглах.	Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн биелэлт	төг				6-9 саруудад	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ/
		Үер усны аюулаас болгоомжлох гарах эрсдлээс сэргийлэх	Усны нөөцийг хэмнэх	Төг	50,0		50,0	6 сард	

3	Хөрсөн бүрхэвч	Машин техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших, талбайг хатуу хучилттай болгох	Хөрсний бохирдол, элэгдэл, эвдэрлийг бууруулах	Төг	100,0	100,0	8 сард	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль -Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага MNS 5915:2008, -Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах техникийн шаардлага MNS 5916:2008,
4	Газрын хэвлий							
5	Ургамалан нөмрөг							
6	Амьтны аймаг	Уурхайн ухаш, мөргөцөгт үргэлж дайчсан, зэрлэг ан амьтан орж гэмтэх, үрэгдэхээс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үйлдвэрийн бүсэд мал амьтан оруулахгүй байх арга хэмжээ авах, Уурхайн ажиллагсдад зэрлэг ан амьтадыг үргээх хууль бусаар агнахыг хориглох	Ан амьтныг хамгаалах, аюул ослоос урьдчилан сэргийлэх	төг	50,0	50,0	2024 оны турш	Амьтны тухай хууль
	нийт					360,0		

VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 онд уурхайн техникийн нөхөн сэргээлтийн ажилд нийт 959,1 мян.төг төлөвлөсөн.

Техникийн нөхөн сэргээлтийг Монгол улсын Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30 –ны өдрийн А-138 дугаар тушаал “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал” -ын дагуу гүйцэтгэж нөхөн сэргээлтэнд гарах зардлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайдын хамтарсан 2010 оны 05 сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалын хавсралтын дагуу хийж гүйцэтгэнэ.

Нөхөн сэргээлтийн ажилд дараах стандарт болон заавруудын шаардлагыг хангах:

- MNS 5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
- MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага
- MNS 4915:2000 Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага
- MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, Хадгалах. Техникийн шаардлага
- MNS 4920:2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
- Ашигт малтмал эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ургамалжуулах заавар (БО -ны болон ХААҮ -ийн сайдын 2000 оны 64/А/62 тоот тушаалын 3-р хавсралт)

Хүснэгт 2. 2024 оны техник болон биологийн нөхөн сэргээлтийн зардал

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Тэгшилгээ, хэлбэржүүлэлт дүүргэлт	Мян.м ³	10.6	90,482	959,1	9-10 сард	1.106° 33' 59.0" 47° 48' 59.1" 2.106° 34' 0.0" 47° 48' 58" 3.106° 34' 0.0" 47° 48' 58" 4.106° 33' 59.0" 47° 48' 59.1" MNS 4915:2000 Ашигт малтмал ашиглах явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн шаардлага, MNS 4920:2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
	Нийт					959,1		

Зураг 1. Техникийн нөхөн сэргээлт хийх талбай болон солбилцолын цэг.



1. 47.814840, 106.568918 2. 47.815153, 106.570425 3. 47.814378, 106.571085 4. 47.814274, 106.569288

6.1. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төлөөлүүлэн хамгаалах газрын байршлыг орон нутгийн захиргаатай хамтран төлөвлөх, саналыг нь тусгаж, хамгаалалтад авна. 2020 онд Чингэлтэй хайрханд харуулын цамхаг хийх ажилд 2 сая төгрөг болон Бага хангай дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Алтганатын овоо нэртэй ууландах ан амьтдад зориулагдсан ухаалаг худаг буюу “уст цэг”- ийг 3 сая төгрөгийг тус тус төсөвлөн хийж гүйцэтгэх ажилд гар бие оролцон хүлээлгэн өгч байсан.

Нийслэлийн байгаль орчны газраас 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Нийслэлийн Байгаль орчны газрын харьяа Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Өлзийт хороололд байрлах мод үржүүлгийн газарт № БО2021/14 тоот гэрээний дагуу 1100 метр 0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барих, гүний худгийн хэрэглээний 380В-ын шит тоноглох ажлыг 2021 оны 06 сарын 11-ээс 2021 оны 06 сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд 6 хүний бүрэлдэхүүнтэй туслан гүйцэтгэгчээр Бажамандал ХХК хийж гүйцэтгэж тус ажилд манай байгууллага 7 сая төгрөг төсөвлөж оролцсон.

Нийслэлийн байгаль орчны газраас 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Нийслэлийн Байгаль орчны газрын

харьяа БХД, 1-р хороо Энгүүн хишиг ХХК -ийн байрт хаягтай Багахангай дүүргийн ОНӨААТҮГ байгууллагын 7,2 га газрын техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхэд 5,5 сая төгрөг зарцуулж оролцлоо.

2023 онд Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн Ойн мэргэжлийн байгууллага болох Нүри ХХК болон Нийслэлийн Байгаль Орчны газартай хамтран Сонгино Хайрхан дүүргийн “Инчон мөрөөдлийн төгөлд” дүйцүүлэн хамгаалах ажлыг 5 га талбайд 6,000 ширхэг шинэс мод тарих үйл ажиллагаанд 3сая төгрөгний төсөвтэй хамтран ажиллаж оролцлоо.

2024 онд Нийслэлийн Байгаль Орчны Газартай зөвшилцөж дүйцүүлэх нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэх ба тус ажлын хүрээнд Нийслэлийн Байгаль орчны газрын харьяа Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Өлзийт хороололд байрлах мод үржүүлгийн газарт мод тарихаар төлөвлөж байна.

Хүснэгт 2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<ul style="list-style-type: none"> - Тухайн төслөөс БОЯБ -д учруулж болох онцгой сөрөг нөлөөг тэглэхэр авсан арга хэмжээ нь хэмжиж болохуйц үр дүнд хүрсэн байх, - Үүсч болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх - Хуримтлагдах нөлөөлөл үүсэхээс сэргийлэх 	<p>Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хөтөлбөр боловсруулах</p> <p>Нийслэлийн Байгаль орчны газрын харьяа Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Өлзийт хороололд байрлах мод үржүүлгийн газарт мод тарих</p>	Төслийн нөлөөлөлд өртөх газар		2 500.0	2024 он	<ul style="list-style-type: none"> - БОНБУ-ний тухай хууль: 3.1.11, 8.4.6, 9.6 - Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам: ЗГ-ын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2-р хавсралт- 5.2 зүйл
Нийт				2 500.0		

6.2. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Уг төсөл маань Улаанбаатар хотын Хан-уул дүүргийн нутаг дэвсгэрт харъяалагддаг, төслийн талбайд айл өрх суурьшаагүй учраас нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал үүсэхээргүй байна.

6.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний нөлөөлийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олоход үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн түүх, археологийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

6.4. Болзошгүй эрсдлээс хамгаалах менежментийн төлөвлөгөө

Уурхайн хайрга олборлолтын үйл ажиллагаанд ямарваа нэг химийн бодис ашигладаггүй нь химийн бодисоос үүсэх эрсдэлгүй тул Болзошгүй эрсдлээс хамгаалах төлөвлөгөөг боловсруулж өглөө.

Хүснэгт 3. Болзошгүй эрсдлээс хамгаалах зардал

Арга хэмжээ	Эрсдлээс хамгаалах арга хэмжээ	Төсөв /мян.төг/	Хугацаа ба давтамж	Гарах үр дүн	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Галын аюулаас хамгаалах багаж хэрэгслийн иж бүрдлийн. Шаардлагатай хэсгийг шинэчлэх	50.0	4-р сар	Аюулыг бууруулах	Гамшгийн тухай хууль
	Болзошгүй эрсдлээс хамгаалсан сургалт зохион байгуулах	-	5-р сар	Эрсдлээс сэргийлэх	
Эрсдэл тохиолдох үед авах арга хэмжээ	Аюул тохиолдсон газрыг хамгаалалтанд авч, хор аюулын таних тэмдэглэгээг байршуулж холбогдох мэргэжлийн байгууллагыг дуудан туслалцаа авах	200,0	Ашиглалтын явцад	Эрсдлийг бууруулах	
Эрсдэл тохиолдсоны дараах үед авах арга хэмжээ	Хяналт, мониторинг хийлгэх, эрсдлийн төлөвлөгөө боловсруулах	50.0	-	Дүгнэлт гаргах	
Нийт төсөв /мян.төг/		300.0			

6.5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалт

Элс, хайрганы хольцын ордын ашиглалттай холбогдож гарах хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалтыг оновчтой шийдвэрлэх зорилгоор журам боловсруулж мөрдөнө. Уг зорилтын хүрээнд хог хаягдал, байгаль орчны талаарх Монгол Улсын хууль, бодлого шийдвэр, дүрэм журмын дагуу, Олон улсын уул уурхайн үйл ажиллагаанд шалгарсан дэвшилтэт арга технологиудыг судална. Энэ талаарх тайлбарыг хаягдлын төрөл тус бүрээр доор оруулав.

Хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах арга хэлбэр:

Тус уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас гарах технологийн хатуу хог хаягдал нь элс-хайрга олборлолтын явц дахь сул чулуулаг болно. Тус уурхай нь хоосон чулуулгийн уурхайн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглана.

Үйлдвэрийн гаралтай металл хаягдлыг тусгай талбайд хурааж, тээвэрлэж, 2-догч түүхий эд болгон борлуулах арга хэмжээг авна.

Мөн ажиллагсдын байрлах байрнаас хатуу хог хаягдал гарна. Үүнийгээ тусгай зориулалтын тагтай саванд хадгалж байгаад тээвэрлэн сумын захиргаатай гэрээ байгуулан тогтмол хугацаанд заасан хогийн цэгт зайлуулна.

Уурхайн үйл ажиллагааны улмаас гарсан хаягдал усанд тогтоосон цэгүүдэд хяналтын шинжилгээг тогтмол хийж, төслийн онцлогт тохирсон хүчин чадалтай бохир ус цэвэрлэх байгууламж ашиглан Цэвэршүүлсэн бохир усыг дахин ашиглах тохиолдолд Ерөнхий шаардлага MNS6734:2018 стандартын дагуу Цэвэрлэсэн усыг дахин ашиглах:

Үүнд:

1. Зам талбайн тоос дарах
2. Суултуур зайлах - ариутгах татуургын засвар үйлчилгээ, гэх зэргийг нэвтрүүлж турших болон хэрэгжүүлэх

Шингэн хаягдал цэвэрлэгээ, арга хэлбэр, зайлуулалт:

Ахуйн шингэн хаягдлыг тусгай бэлтгэсэн нүхэнд хаяхын зэрэгцээ бие засах газрыг эрүүл ахуйн талаас нь стандартын шаардлага хангахуйц бетонон доторлогоо хийх, засаж тохижуулж үнэр болон бусад сөрөг нөлөөлөл үүсэхээс урьдчилан сэргийлж байгуулах болно.

Хүснэгт 4. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

№	Хог хаягдлын төрөл	Арга хэмжээ	Жилд гарах хэмжээ	Төсөв /мян.төг/	Хугацаа ба давтамж	Гарах үр дүн	Стандарт
1	Хатуу хог хаягдал	Түүхий эдийн хог хаягдлыг тараахгүй байлгах	-	-	2024 оны турш	Талбайн тархалтыг бууруулах	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Хаягдал усыг зайлуулах цэг тогтоох журам, Ариун цэврийн тухай хууль
		Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний явцад гарсан аюултай хог хаягдлыг контейнерт хадгалах /аккумулятор, баттерей Ашиглагдсан шатах тослох материал, тос маслын сав г.м./	Бүртгэл хөтөлж хаягдлын хэмжээг гаргана.	-	Сар бүр	Эрдлээс хамгаалах	
2	Шингэн хог хаягдал	-Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS5924:2015 стандартын дагуу нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжийг төлөвлөх.		300.0	8-р сард	Бохирьг хөрсөнд нэвчихээс хамгаалах	
		Ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийх	33.6 м ³	2 удаа * 50.0 = 100.0	Жилд 2 удаа	Бохирдлоос хамгаалах	
		Ашиглагдсан шатах тослох материалыг битүү саванд хадгалж байгаад дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлнэ.	-	-	2024 он	Бохирдлоос хамгаалах	
3	Ахуйн хог хаягдал	Шаардлага хангасан цэгт төвлөрүүлж орон нутагтай хог ашиглалтын гэрээ хийж зайлуулна.	0.72 тн	160.0	2024 он	Салхинд хийсэхээс хамгаалах	
		Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, ШТС –ын агуулах зэрэг газарт шинэ 3 өнгийн хогийн сав байрлуулах		400,0	9 сард	Бохирдлоос хамгаалах	
	Нийт төсөв /мян.төг/			960,0			

6.6. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Өвөр харзат” ХХК” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

“Өвөр харзат” ХХК” ХХК -ийн Улаанбаатар хотын Хан-уул дүүргийн 13 дугаар хорооны нутагт орших “Харзатын хотгор” барилгын материалын үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхэд дээрх аргачлалын дагуу “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”-ийг явуулах үүрэгтэй бөгөөд гаргах зардлыг тус компани нь бүрэн хариуцна.

Энэхүү орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн зардлыг гаргахдаа ЦУОШГ, Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори, Геологийн төв лаборатори, ШУА-ийн Геоэколийн хүрээлэнгийн хөрсний лабортори, хөрсний хортой хүнд хортой элементийг “Алс групп” ХХК -ийн лаборотори болон ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторид мөрдөгдөж буй үнийг үндэслэн зардлын тооцоог гаргав.

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар						
1.1	Агаарын бохирдол, тоосжилтын шинжилгээ хийлгэх	Уурхайлалт явагдаж буй талбайд	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд	Жил тутамд	120.0 х 2 цэг х жилд 1 удаа НИЙТ 240.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
Хөрсний бохирдол						
2.1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 3 цэг сонгох ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэг, уурхайн талбайд	Жил тутамд	3 цэгт х 2 дээж х жилд 1 удаа х /40.0/ НИЙТ 240.0 /Хөрсний агрохимийн шинжилгээ 1 дээж -40.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох	Дээрх 3 цэгт	Жилд 1 удаа	3 цэгт х 2 дээж х жилд 1 удаа х 33,0 Нийт 198.0 хүнд металлын шинжилгээ 1 дээж- 33.0 төг/	MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтний спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Усны хяналт шинжилгээ						
2.1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Харзатын хотгор	Жилд 1 удаа	42.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900: 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Ургамлын аймаг						
3.1	Ургамал устгах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, биомасс, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамал	Төсөл хэрэгжиж буй талбай болон түүний ойр орчим 2 цэгт	Жилд 1 удаа	-	Мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					720.0	

Хүснэгт 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Авах арга хэмжээ	Хугацаа, давтамж	Урьдчилсан зардал, мян.төг	Хамтран хэрэгжүүлэгч	Гарах үр дүн
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг ажилчдад хийх	2024 онд	1 удаа*10 хүн*5.0 = 50.0	Мэргэжлийн байгууллага	Ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдлыг бууруулах
2	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбарыг уурхайн кэмп, төв хаалга, уурхайлалтын бүсэд байрлуулах	2024 онд		“Өвөр харзат” ХХК	
3	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж галын дүгнэлт гаргуулах, түймэр унтраах	2024 онд	150,0	Мэргэжлийн байгууллага	Гал түймрийн аюул, эрсдлээс бүрэн сэргийлэх
	дүн		200.0		

6.7. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Хүснэгт 5. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Аймаг, Багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах	-
НБОГ	-	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	-	-

6.8. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН НЭГДСЭН ДҮН

Хүснэгт 6. Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулах зардлын нэгдсэн дүн

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Хөрөнгийн хэмжээ мян/төг	Хугацаа
1	Сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан/	Мян.төг	360.0	2024 он
2	Нөхөн сэргээлтийн зардал	Мян.төг	959,1	2024 он
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян.төг	2 500.0	2024 он
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Мян.төг	-	2024 он
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян.төг	-	2024 он
6	Болзошгүй осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	Мян.төг	300.0	2024 он
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	Мян.төг	960.0	2024 он
8	Удирдлага-зохион байгуулалтын болон бусад арга хэмжээ	Мян.төг	200.0	2024 он
9	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	Мян.төг	720.0	2024 он
10	БОМТ-г орон нутагт тайлагнах		-	2024 он
	Дүн		5 999.1	2024 он